6. Газрын тосны 20-иос доошгүй хоногийн нөөцтэй байх талаар газрын тосны бүтээгдэхүүний импорт, худалдаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагатай тохиролцож, ургац хураалтын үед бензин шатахуун тасалдуулахгүй байх арга хэмжээ авахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай нарт даалгасугай.

7. Сүүлийн жилүүдэд зарим аймгийн нутгийг хамарсан хүчтэй цасан болон шороон шуурганы улмаас ихээхэн хэмжээний хохирол учирч байгаатай холбогдуулан энэ талаар хайгуул судалгаа хийж, шинжлэх ухаан технологийн сангаас санхүүжүүлэн тодорхой төсөл хэрэгжүүлэн Сүхбаатар, Дорнод, Хэнтий аймгийн зонхилох салхины замд салхины хүчийг хагалах, сулруулах, салхинаас хамгаалах байгууламж барих шийдэл гаргах арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, Сүхбаатар, Дорнод, Хэнтий аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

8. Телевиз, үүрэн телефон, интернет зэрэг мэдээллийн технологийн орчин үеийн арга хэлбэрийг ашиглан нийтэд зориулсан цаг агаарын урьдчилан сэргийлэх болон сэрэмжлүүлэх мэдээ, мэдээллийг олон нийтэд үнэн бодитой, шуурхай хүргэж байх талаар тодорхой арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүхэд даалгасугай.

9. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд даалгасугай:

а) мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөө гарган түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр аймаг, нийслэлийн Засаг дарга нарт албан даалгавар өгч биелэлтэд хяналт тавьж ажиллан, шаардлагатай арга хэмжээг холбогдох яам, газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран хэрэгжүүлэх;

б) уринш боловсруулах, ургац хураах ажлыг технологийн хугацаанд зохион байгуулж, шаардагдах техник, тоног төхөөрөмжийг худалдан авах, нийлүүлэх болон элеватор, агуулахыг засварлаж шинэчлэх ажлыг шуурхай хийж, тэдгээрийн бэлэн байдлыг хангах арга хэмжээ авах;

в) дараа оны тариалалтад хүрэлцэхүйц хэмжээний чанар сайтай үрийн буудай аж ахуйн нэгжид нөөцлүүлэх, өмнөх онуудад иргэн, аж ахуйн нэгжид зээлээр олгосон үрийн будаа, техник, тоног төхөөрөмжийн үнийг төлүүлэх ажлыг зохион байгуулах;

г) Хэрлэнбаян-Улааны аймаг дундын отрын бүс нутгаас нүүлгэн шилжүүлэх өрх, малыг өвөлжүүлж, хаваржуулах газар нутгийг сонгон, холбогдох аймагтай тодорхой гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах.

10. Дараахь арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай:

а) аймаг, нийслэлийн хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж, энэхүү тогтоолын хавсралтаар баталсан 2009 онд бэлтгэх хадлан, тэжээлийн даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулах;

б) орон нутгийн эрчим хүчний үйлдвэр, нийт аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өвлийн бэлтгэлийг хангуулах, түлээ, нүүрс нөөцлөх, түлш, шатахуун татан авах ажлыг зохион байгуулж энэ оны 10 дугаар сарын 1-ний дотор нүүрс, шатахуун, дизелийн түлшний 20-иос доошгүй хоногийн нөөцийг бүрдүүлж, төв, суурин газрын барилга байгууламж, орон сууцны цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээний ээлжит засвар, үйлчилгээ, угаалга, туршилт, автозам, харилцаа холбооны шугамын арчлалт, үйлчилгээг төлөвлөсөн хугацаанд нь хийж дуусгах арга хэмжээ авах;

в) нийтийн тээврийн хэрэгсэл, тэдгээрийн гараашийн засвар, дулаалгыг хугацаанд нь чанартай хийж, сэлбэг хэрэгсэл, өвлийн улирлын шатахуун, тослох материалыг зохих хэмжээнд нь нөөцөлж, иргэдэд найдвартай үйлчлэх нөхцөл бүрдүүлэх;

г) нутаг дэвсгэрийнхээ зуншлага, намаржилтын байдалтай уялдуулан мал өвөлжүүлэх, отор нүүдэл хийх, хадлангийн газрын ашиглалтын төлөвлөгөө, зураглал гарган мөрдөн ажиллаж, шаардлагатай үед нөөц бэлчээрийг ашиглах талаар гэрээ байгуулах асуудлыг урьдчилан тохиролцох;

д) аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг шаардлагатай цэгүүдэд байршуулах арга хэмжээ авах;

е) өвөлжилтийн бэлтгэл ажилд иргэд, малчид, аж ахуйн нэгж, байгууллагын хүч анхаарлыг төвлөрүүлж орон нутагт зохион байгуулах найр, наадмыг хязгаарлах арга хэмжээ авах.

11. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж, түлш, эрчим хүчний салбарын болон мал өвөлжилтийн бэлтгэл ажлын явцыг сар бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай нарт тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙ САЙД** **С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,**
**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ**
**ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА** **Б.ДОЛГОР**

Засгийн газрын 2009 оны 221 дүгээр тогтоолын хавсралт

## АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД 2009 ОНД БЭЛТГЭХ ХАДЛАН, ТЭЖЭЭЛИЙН ДААЛГАВАР

| № | Аймгийн нэр | Бэлтгэх нийт тэжээл (мян.тн) | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Бүдүүн тэжээл | | | Хүчит тэжээл | |
| | | Өвс | Сүрэл | Ногоон тэжээл | Үйлдвэрийн тэжээл | Гар тэжээл |
| 1 | Архангай | 70.0 | 0.6 | 0.6 | - | 1.0 |
| 2 | Баян-Өлгий | 35.0 | - | - | 10.0 | 2.5 |
| 3 | Баянхонгор | 35.0 | | 1.0 | 1.0 | 3.5 |
| 4 | Булган | 80.0 | 4.0 | 3.0 | 9.0 | 1.5 |
| 5 | Говь-Алтай | 25.0 | 0.8 | 1.0 | 0.4 | 3.5 |
| 6 | Дорноговь | 15.0 | - | - | 0.2 | 2.0 |
| 7 | Дорнод | 55.0 | - | 1.0 | 0.2 | 1.0 |
| 8 | Дундговь | 20.0 | - | - | 0.2 | 4.0 |
| 9 | Завхан | 40.0 | - | 0.5 | 2.0 | 2.0 |
| 10 | Өвөрхангай | 35.0 | - | - | 2.0 | 2.0 |
| 11 | Өмнөговь | 10.0 | - | - | 0.5 | 5.0 |
| 12 | Сүхбаатар | 45.0 | - | 0.2 | 2.0 | 4.0 |
| 13 | Сэлэнгэ | 120.0 | 15.0 | 10.0 | 15.0 | 1.0 |
| 14 | Төв | 85.0 | 10.0 | 5.0 | 10.0 | 2.0 |
| 15 | Увс | 35.0 | 2.0 | 1.0 | 1.5 | 3.5 |
| 16 | Ховд | 45.0 | - | - | - | 3.7 |
| 17 | Хөвсгөл | 70.0 | 1.0 | 0.3 | 0.6 | 2.0 |
| 18 | Хэнтий | 80.0 | 2.0 | 1.0 | 4.0 | 2.0 |
| 19 | Дархан-Уул | 45.0 | 2.0 | 5.0 | 4.0 | 0.5 |
| 20 | Орхон | 10.0 | 1.0 | 1.0 | 5.0 | 1.0 |
| 21 | Говьсүмбэр | 5.0 | - | - | 1.0 | 2.0 |
| 22 | Улаанбаатар | 45.0 | - | 2.0 | 25.0 | 1.0 |
| Улсын дүн | | 1005.0 | 38.4 | 32.6 | 93.6 | 50.7 |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2008 оны 07 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 222 | Улаанбаатар хот |

**Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай**

"Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2009 оны 45 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралт, "Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөрийн төлөвлөгөө"-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлсугай.

2. Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Долгор, Цөмийн энергийн газрын дарга С.Энхбат нарт үүрэг болгосугай.

3. Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Цөмийн энергийн газрын дарга С.Энхбатад даалгасугай.

4. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд С.Баярцогтод үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙ САЙД** **С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,**
**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ**
**ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА** **Б.ДОЛГОР**

**Засгийн газрын 2009 оны 222 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт**

### МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ЦАЦРАГ ИДЭВХТ АШИГТ МАЛТМАЛ БОЛОН ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

**Нэг.Хөтөлбөр боловсруулах үндэслэл**

Дэлхийн улс орнууд хүний эрүүл мэндэд халгүй, экологийн хувьд

цэвэр, байгаль орчинд ээлтэй технологиор эдийн засгийн хувьд үр ашигтай, өртөг багатай цөмийн энерги ашиглах бодлого баримталж байна.

Цөмийн эрчим хүчний гол түүхий эд болох цацраг идэвхт ашигт малтмалыг ашиглах асуудалд дэлхий нийтийн анхаарал улам нэмэгдэж, цацраг идэвхт ашигт малтмалын эрэлт хэрэгцээ огцом өсч, зах зээл дэх түүний үнэ сүүлийн 10 гаруй жилийн дотор 15 дахин нэмэгдсэн.

Австрали, БНКазУ, Канад зэрэг улсын цацраг идэвхт ашигт малтмалын нөөц дэлхийн цацраг идэвхт ашигт малтмалын нөөцийн 60 гаруй хувийг эзэлж байна.

Монгол Улс цацраг идэвхт ашигт малтмалыг ашиглах асуудалд онцгой анхаарч, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлөөр цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн эрчим хүч ашиглах асуудлыг удаа дараа хэлэлцэн зөвлөмж гаргасан бөгөөд 2007 онд Улсын Их Хурал цацраг идэвхт ашигт малтмалын зарим ордыг стратегийн ач холбогдол бүхий ордод хамааруулсан. Манай улсын ураны батлагдсан нөөц 65 мянга орчим тонн бөгөөд нийт нөөц баялаг 1.4 сая тоннд хүрэх боломжтой гэсэн урьдчилсан тооцоо байдаг.

Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах нь манай улсын тогтвортой хөгжил, эдийн засгийн болон эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, ард түмний амьдралын түвшинг дээшлүүлэхэд нөлөөлөх чухал хүчин зүйл болно.

**Хоёр.Хөтөлбөрийн зорилго**

2.1. Хөтөлбөрийн зорилго нь "Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх, цацраг идэвхт ашигт малтмалын судалгаа, эрэл, хайгуул хийх, олборлох, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэн, экспортын шинэ эх үүсвэрийг бий болгох, цөмийн энерги ашиглах замаар Монгол Улсын эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, тогтвортой хөгжлийн нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

**Гурав. Хөтөлбөрийн зорилт**

3.1. Хөтөлбөрийн зорилгыг биелүүлэхийн тулд дараахь зорилтыг хэрэгжүүлнэ:

3.1.1. цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах удирдлага, хяналтын тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг бүрдүүлэх;

3.1.2. цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3.1.3. цацраг идэвхт ашигт малтмалын судалгаа, эрэл хайгуулын ажлыг өргөжүүлэх замаар түүний нөөц (батлагдсан)-ийг нэмэгдүүлэх;

3.1.4. цацраг идэвхт ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт,

4.6.3. цөмийн эрчим хүчний эх үүсвэрийг дэд бүтцийн хамт барьж байгуулах;

4.6.4. цөмийн эрчим хүч ашиглахын ач холбогдол, эдийн засгийн үр нөлөө, байгаль экологийн ашиг тусыг олон нийтэд сурталчлан таниулах;

4.6.5. гадаад орнуудад цөмийн энерги ашиглаж байгаа үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах, хамтын ажиллагааг хөгжүүлэх.

4.7. Хөтөлбөрийн 3.1.7 дахь зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.7.1. цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдалд хяналт тавих үндэсний дэд бүтэц, хяналтын тогтолцоог олон улсын стандартын шаардлагад нийцүүлэх арга хэмжээ авах;

4.7.2. цөмийн аюулгүй байдал, цацрагийн хамгаалалтын техникийн чадавхийг бэхжүүлэх, дотоод шарлагын болон дозиметрийн тохируулгын хоёрдогч стандартын лабораторийг шинээр байгуулах;

4.7.3. цацрагийн аюулгүй байдлыг хянах орчны мониторингийн тогтолцоог бий болгох, хяналтын лаборатори байгуулах;

4.7.4. цөмийн болон цацрагийн болзошгүй ослын үед хэрэгжүүлэх арга хэмжээний үндэсний төлөвлөгөөг боловсруулах, цацрагийн хамгаалалтын техник, хэрэгслээр хангах;

4.7.5. улсын хилээр цөмийн материал, цацрагийн үүсгүүрийг хууль бусаар нэвтрүүлэхээс сэргийлсэн хяналтыг сайжруулах.

**Тав. Хөтөлбөр хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт**

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, ажлын явц, үр дүнд тавих хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог шинээр боловсруулж хэрэгжүүлэх ажлыг Цөмийн энергийн газар болон Цөмийн энергийн комисс хариуцан зохион байгуулна.

5.2. Хөтөлбөрийг "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого"-той уялдуулан хэрэгжүүлнэ.

5.3. Холбогдох төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг эрхэлсэн салбар, хариуцсан чиг үүргийнхээ дагуу нарийвчлан боловсруулж, хэрэгжүүлнэ.

5.4. Цацраг идэвхт ашигт малтмал олборлох, боловсруулах, экспортлох, цөмийн энерги ашиглах үйл ажиллагааны ач холбогдлын талаар олон нийтэд оновчтой, хүртээмжтэй хэлбэрээр сурталчилж, нийгмийн сэтгэл зүйг бэлтгэх, дэмжлэг авах талаар анхаарч ажиллана.

5.5. Хөтөлбөр хэрэгжүүлэх явцад тохиолдож болох эрсдэл, саад бэрхшээлийг урьдчилан судалж нарийвчлан тооцоолох, түүнээс сэргийлэх, арилгах, даван туулах арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлнэ.

**Зургаа. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа, үе шат**

6.1. Хөтөлбөрийг хоёр үе шаттай хэрэгжүүлнэ:

6.1.1. нэгдүгээр үе шат (2009-2012 он)-д хөтөлбөрийн үндсэн зорилго, зорилтуудыг биелүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжүүлж эхлэх бүх талын нөхцөлийг хангана;

6.1.2. хоёрдугаар үе шат (2013-2021 он)-д хөтөлбөрт заасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлнэ.

**Долоо. Хөтөлбөр хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилт**

7.1. Хөтөлбөрийг дараах хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлнэ:

7.1.1. улсын төсөв;

7.1.2. хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт;

7.1.3. гадаадын зээл, тусламж.

7.2. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, улсын төсөвт тусган санхүүжүүлнэ.

7.3. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд урьдчилсан тооцоогоор нийт 4 их наяд 394 тэрбум 169 сая төгрөг (улсын төсөв 1.17%, хувийн хэвшлийн хөрөнгө 98.11%, зээл, тусламж 0.71%) шаардагдана.

**Найм. Шалгуур үзүүлэлт, үр дүн**

Хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт:

8.1. Нэгдүгээр үе шатанд:

8.1.1. цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах эрх зүйн орчин олон улсын жишигт нийцсэн байна;

8.1.2. цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн судалгааны материал, лабораторийн бааз бүрдсэн байна;

8.1.3. стратегийн хөрөнгө оруулагчтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлсэн байна;

8.1.4. цацраг идэвхт ашигт малтмал олборлолтын ажил эхэлсэн байна;

8.1.5. цацраг идэвхт ашигт малтмал ашиглахтай холбогдсон хяналтын эрх зүйн тогтолцоо олон улсын жишигт хүрсэн байна.

8.2. Хоёрдугаар үе шатанд:

8.2.1. цацраг идэвхт ашигт малтмалыг боловсруулж экспортлох нөхцөл бүрдсэн байна;

8.2.2. цөмийн эрчим хүчний салбарт үндэсний мэргэжилтэн бэлтгэгдсэн байна;

8.2.3. цөмийн эрчим хүчний эх үүсвэрийг барьж байгуулна;

8.2.4. цөмийн эрчим хүч ашиглаж эхэлнэ;

8.2.5. цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн эрчим хүч ашиглах тогтвортой ажиллагаа бий болно.

Засгийн газрын 2009 оны 222 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ЦАЦРАГ ИДЭВХТ АШИГТ МАЛТМАЛ БОЛОН ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

(сая.төгрөг)

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэх байгууллага | Оролцогч талууд | Хугацаа | Урьдчилсан байдлаар тооцсон төсөв | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Улсын төсвийн хөрөнгө | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | Зээл тусламж |
| | *Нэг. Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах удирдлага, хяналтын тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг бүрдүүлэх* | | | | | | |
| 1 | Ерөнхий сайдын эрхлэх ажлын үндсэн хүрээнд ажиллах цөмийн энергийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн тогтоох, үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх | ЗГХЭГ, ЦЭГ | | 2009 | | | |
| 2 | Цөмийн судалгаа, технологийн үндэсний хүрээлэнг байгуулах | ЗГХЭГ, БСШУЯ | ЦЭГ | 2009 | 4000.0 | | 5000.0 |
| 3 | Цацраг идэвхт ашигт малтмалын судалгаа, эрэл, хайгуул, олборлолт, боловсруулалт, цөмийн эрчим хүч ашиглах үйл ажиллагааг эрхлэх төрийн өмчит компани байгуулах, өргөжүүлэн хөгжүүлэх | ЭБЭХЯ, ЦЭГ | ТӨХ | 2009 | 100.0 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| *Хоёр. Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлэх* | | | | | | | |
| 1 | Цацраг идэвхт ашигт малтмалын судалгаа, эрэл, хайгуул, олборлолт, боловсруулалт, цөмийн энерги ашиглах, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэх | ЭБЭХЯ, ЦЭГ | ХЗДХЯ, ТӨХ | 2009.YШ сар | 1.0 | | |
| 2 | Цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдалтай холбоотой дүрэм, журам, стандартыг олон улсын шаардлагад нийцүүлэн шинэчлэн баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | ЦЭГ | ХЗДХЯ, ЭБЭХЯ, СХЗГ | 2009-2010 | 100.0 | | 100.0 |
| *Гурав. Цацраг идэвхт ашигт малтмалын нөөц /батлагдсан/-ийг нэмэгдүүлэх, ашиглах* | | | | | | | |
| 1 | Цацраг идэвхт ашигт малтмалын судалгаа, эрэл, хайгуулын ажлыг өргөжүүлэх замаар түүний нөөц /батлагдсан/-ийг нэмэгдүүлэх | ЭБЭХЯ | ЦЭГ | 2009-2015 | 15000.0 | 400000.0 | |
| 2 | Хамтарч ажиллах стратегийн хөрөнгө оруулагч (СХО)-ийг сонгон шалгаруулах ажиллагаа, түүнд тавих нөхцөл, шаардлагыг боловсруулж, хэрэгжүүлэх | ЭБЭХЯ, ТӨХ, ЦЭГ | ХЗДХЯ, ГХЯ, ТЕГ | 2009.IX сар | 10.0 | | 50.0 |
| 3 | Цацраг идэвхт ашигт малтмал ашиглаж байгаа зарим гадаад улсуудаас туршлага судлах ажлыг зохион байгуулах | СЯ, ЦЭГ | ХЗДХЯ, ГХЯ, ЭБЭХЯ | 2009 | 30.0 | | 100.0 |

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

| | | |
|---|---|---|
| 2009 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр | Дугаар 04 | Улаанбаатар хот |

**Монгол Улсын Их Хурлын сонгуулийн/ тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 12.45 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат, Н.Жанцан, Д.Наранчимэг /илтгэгч/, Ц.Сарантуяа нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Н.Болортунгалагийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Б.Лхагважав, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар оролцов.

Хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9, 10, Арван есдүгээр зүйлийн 1, Дөчин долдугаар зүйлийн 1, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэв.

**Нэг. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны оршин суугч, иргэн Б.Лхагважав 2009 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:**

"...Монгол Улсын Их Хурлаас 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь хэсэгт зааснаар "өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол" 26 дугаар зүйлийн 26.3 дахь заалтын дагуу нам, эвслийг Сонгуулийн ерөнхий хороо бүртгэхээс татгалзаж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт "...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...", Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалт "...Аль нэгэн нам, ...гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "...Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ...хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх..." тухай Үндсэн хуулийн хэм хэмжээг тус тус зөрчсөн байна" гээд,

"Нам, эвсэл нь сонгуулийн зардлын тайланг гаргаж өгөөгүй, эсвэл

хоцруулсан алдаатай үйлдлийнхээ төлөө Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.8 дахь хэсгийн заалтын дагуу 800000-1000000 хүртэл төгрөгөөр торгуулах шийтгэл хүлээж байгаа. Гэтэл энэхүү нэг удаагийн алдаатай үйлдлийнхээ төлөө дахин сонгуульд оролцох эрхээ хасуулна гэдэг нь хууль зүйн шинжлэх ухааны нэг алдаанд нэг шийтгэл оногдуулах зарчмыг алдагдуулж байна. Аль нэг намын хариуцлагагүй ажилтны алдаанаас болж бусад гишүүд болон ирээдүйн гишүүд, дэмжигчдийн ардчиллын үнэт зүйлс болсон сонгох, сонгогдох эрхийг хязгаарлах нь утгагүй юм.

Иймд Монгол Улсын иргэний эрхэд халдсан, Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дээр дурдсан заалтыг хүчингүй болгож өгнө үү" гэжээ.

**Хоёр. Иргэн Б.Лхагважав Үндсэн хуулийн цэцэд 2009 оны 9 дүгээр сарын 30-ний өдөр ирүүлсэн нэмэлт тайлбартаа:**

"...Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалт нь Монгол Улсын Их Хурлаас 2005 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр баталсан Улс төрийн намын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-д заасан "Монгол Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох эрхтэй" гэснийг зөрчиж байна.

Улс төрийн намын энэ чухал эрх нь Улс төрийн намын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэгт заасны дагуу л алга болно. Эндээс үүдээд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалт нь намын дотоод асуудалд шүүхийн ч оролцоогүй үйл ажиллагаанд оролцсон, мөн Улсын Дээд шүүхийн бүрэн эрх буюу Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Улс төрийн намын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.3, 3.6 дахь хэсгийн заалтуудаар хангагдах намд эвлэлдэн нэгдэх Монгол Улсын иргэний эрхэд халдаж байгаа нь Үндсэн хуулийн цэцэд өмнө гаргасан мэдээлэлтэй утга адил юм" гэжээ.

**Гурав. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Б.Чойжилсүрэн нар Үндсэн хуулийн цэцэд хандаж 2009 оны 10 дугаар сарын 19-ний өдөр ирүүлсэн тайлбартаа:**

"Нэг. "Нам, эвсэл нь сонгуулийн зардлын тайланг гаргаж өгөөгүй, эсвэл хоцруулсан алдаатай үйлдлийнхээ төлөө Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.8 дахь хэсэгт заасны дагуу 800000-1000000 төгрөгөөр торгуулах шийтгэл эдэлж байгаа. Гэтэл энэхүү нэг удаагийн алдаатай үйлдлийн төлөө дахин сонгуульд оролцох эрхээ хасуулна гэдэг нь хууль зүйн ухааны нэг алдаанд нэг шийтгэл ногдуулдаг зарчмыг алдагдуулж байна. Аль нэг намын хариуцлагагүй ажилтны алдаанаас болж бусад гишүүд болон ирээдүйн гишүүд, дэмжигч нарын

ардчиллын үнэт зүйл болох сонгох, сонгогдох эрх нь хязгаарлагдах нь" гэсэн талаар:

Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр зүйлд нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл гэж заасан бөгөөд нам нь үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнолыг хангах, нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлэх, үйл ажиллагаагаа ил тод явуулах зарчмыг баримтлахаар заасан байдаг.

Сонгуулийн санхүүжилтийн үйл ажиллагааны бүх явц, үр дүнгийн нэг гол үндэслэл, хэлбэр нь сонгуулийн санхүүгийн тайлан юм. Энэ нь угтаа сонгуулийн хуулийн биелэлтийн мөнгөн илэрхийлэл, хяналтын гол хэлбэр болно.

Иймч учраас сонгуульд оролцсон нам, эвсэл нь сонгуулийн зардлын тайланг санал хурааж дууссан өдрөөс хойш нэг сарын дотор гаргаж өгөөгүй тохиолдолд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.8-д заасны дагуу 800000-1000000 төгрөгөөр торгох захиргааны шийтгэлийг сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч ногдуулах ба харин мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6-д заасан Сонгуулийн ерөнхий хорооноос нам, эвслийг бүртгэхээс татгалзах зохицуулалт нь уг зөрчилд давхар оногдуулж буй шийтгэл бус харин дараагийн нөхөн сонгууль болон ээлжит сонгууль явагдахад өмнөх сонгуулийн дараа гарч байсан холбогдох зөрчил арилаагүй, үргэлжилсээр байх тохиолдолд, өөрөөр хэлбэл, өмнөх сонгуулийн зардлын тайланг гаргаж өгөөгүй хэвээр байгаа тохиолдолд авч буй хариуцлагын арга хэмжээ юм.

Хоёр. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад заасан "...төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...", мөн зүйлийн 10 дахь хэсэгт заасан "Аль нэг нам, ...гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно..." гэснийг зөрчсөн гэсэн талаар:

Хүний сонгох, сонгогдох эрхийг хангах, уг эрх хэрэгжих нэг үндэс нь сонгогчид бүхэлдээ сонгуулийн талаар мэдээллээр хангагдах явдал юм.

Сонгуулийн шударга, ил тод байх, хууль дээдлэх зарчмыг хангах үндсэн зарчмын нэг болсон санхүүжилтийн ил тод байдлыг зөрчиж, хуульд заасан үүргээ дараагийн сонгууль зарлах хүртэл хугацаанд биелүүлээгүй улс төрийн намыг сонгуульд бүртгэхээс татгалзах талаар зохицуулсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтын зохицуулалт нь иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хязгаарлаж байгаа бус, харин ч иргэд шударга, чөлөөт сонгуулийн үндсэн дээр сонгуулийн эрхээ хэрэгжүүлэх хууль зүйн баталгаа болж байна гэж үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь

хэсэгт болон Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу "...нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлэх...", "...үйл ажиллагаагаа ил тод явуулах..." зарчмыг хэрэгжүүлэх нь улс төрийн намын үүрэг байдаг.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар өмнөх сонгуулийн зардлын тайлангаа гаргаж өгөх үүргийг сонгуульд оролцсон улс төрийн намуудад бүгдэд нь нэгэн адил хүлээлгэдэг бөгөөд харин хуулийн шаардлагыг дараагийн сонгууль хүртэлх хугацаанд биелүүлээгүй зөрчил гаргасан улс төрийн намыг Сонгуулийн ерөнхий хорооноос бүртгэхээс татгалздаг зохицуулалт нь тухайн хууль зөрчсөн улс төрийн намд хуулийн дагуу хариуцлага оногдуулж байгаа асуудал бөгөөд үүнийг тухайн намын гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхсан, хэлмэгдүүлсэн, аль нэг намд давуу эрх олгосон зохицуулалт гэх хууль зүйн үндэслэлгүй болно.

Гурав. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх..." гэсэн хэм хэмжээг зөрчсөн гэсэн талаар:

Сонгуульд оролцогч улс төрийн нам, нэр дэвшигчид сонгуулийн дансанд оруулсан хөрөнгийг хуульд заасан зориулалт, хязгаарлалтын хүрээнд ашиглах, сонгуулийн санхүүжилт, зардлыг нээлттэй ил тод байлгах асуудал нь сонгуулийн тэгш, шударга байдлыг хангах, иргэний улс төрийн эрхийг баталгаатай хангах үндэс болно. Сонгогч нь сонгуульд нэр дэвшигч, сонгогдогчийн үйл ажиллагааны талаар аливаа мэдээлэл, түүний дотор сонгуулийн санхүүжилт, хандивтай холбоотой мэдээлэл авах эрхтэй. Энэ нь сонгуулиар далимдуулан хууль бусаар мөнгө хуримтлуулах, төсвийн хөрөнгийг ашиглах зэрэг санхүүгийн булхайг таслан зогсооход тун чухал.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтын зохицуулалт нь сонгуулийг нээлттэй ил тод, шударга, үр дүн нь бодитой байх, улмаар иргэдийн сонгуулийн эрхийг хангах хууль зүйн нэг гол баталгаа болсон гэж үзэж байна" гэжээ.

**ҮНДЭСЛЭЛ:**

1.Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт зааснаар Сонгуулийн ерөнхий хороо нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах эрхтэй төрийн байгууллага атал түүнд улс төрийн нам, эвслийг өмнөх сонгуулийн зардлын тайланг ирүүлээгүй, хугацаанд нь ирүүлээгүй гэсэн шалтгаанаар бүртгэхээс татгалзаж сонгуульд оролцох эрхийг хасах эрх хэмжээг Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтаар олгосон нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулж байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалт нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "...Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ...хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх...", Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ", Тавьдугаар